



## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

### “Цодгор хүү-2014” шатрын тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5, 16.1 дэхь заалт, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах “Цодгор хүү-2014” шатрын тэмцээнийг 2014 оны 01 дүгээр сарын 04-06-ны өдрүүдэд Монгол туургатны “Урамтай шатар” холбооны спорт зааланд зохион байгуулсугай.
2. Шатрын тэмцээний төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. “Цодгор хүү-2014” шатрын тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 870.000 /найман зуун далан мянган/ төгрөгийг Нийслэлийн биеийн тамир, спортын газрын төвлөрсөн төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.
4. Тэмцээнийг зааврын дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг мэргэжилтэн Б.Батсайханд үүрэг болгосугай.

ДАРГА




Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500003

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын  
2014 оны цадгуур сарын 02-ны өдрийн  
А/02 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“ЦОДГОР ХҮҮ-2014” шатрын тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 6 x 30.000 төг = 180.000 төг 6 x 25.000 төг = 150.000 төг 6 x 20.000 төг = 120.000 төг	450.000
2.	Шүүгчдийн ажлын хөлс: /5 хүн x 3өдөр x 20.000 төг/	180.000
3.	Диплом, өргөмжлөл /30ш x 2.000 төг/	60.000
4.	Медаль: /18 x 6.000 төг/	108.000
5.	Анонс /4м x 3м/ x 6000	72.000
ДҮН:		870.000 төг

Боловсруулсан  
Хянасан

Б.Батсайхан  
О.Эрдэнэцэцэг